

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: АНУ-ын хөрөнгийн зах зээлийн Dow Jones болон S&P 500 индексүүд бүх цаг үеийн дээд түвшинд хүрч хаагдсан бол Nasdaq индекс буурсан үзүүлэлттэй байна. АНУ-ын Засгийн газрын урт хугацаат бондын өгөөж нэмэгдсэнээр санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниудын хувьцааны ханш өсчээ. Харин бондын өгөөж нэмэгдсэнтэй холбоотойгоор үл хөдлөх хөрөнгө болон өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгч компаниудын ногдол ашгийн хэмжээ хөрөнгө оруулагчдын анхаарлыг татахаа больсон бөгөөд эдгээр компаниудын хувьцааны ханш буурсан байна.

АНУ, БНХАУ хоорондын худалдааны маргаан хөрөнгийн зах зээлд төдийлөн нөлөө үзүүлсэнгүй. Энэ долоо хоногт АНУ-ын Ерөнхийлөгч Хятад улсын 200 тэрбум ам.доллартай тэнцэх импортын бараа бүтээгдэхүүнд 10 хувийн гаалийн татвар ногдуулан, оны эцэст татварын хэмжээг 25% болгон өсгөх талаар мэдээлсэн. Хөрөнгө оруулагчдын үзэж байгаагаар гаалийн татварын хэмжээ харьцангуй бага буюу 10% байгаа нь АНУ-ыг Хятад улстай хэлэлцээр хийхэд бэлэн байгааг илтгэж байгаа аж.

Европ: Европын зах зээлийн индексүүд АНУ, БНХАУ-ын худалдааны маргаан болон Brexit хэлэлцээрийг тойрсон асуудлуудыг үл харгалзан өсөлттэй хаагдлаа.

Их Британийг ЕХ-ноос гарах тухай хэлэлцээрийг эцэслэн батлах, Ирландтай залгаа хилийн асуудлыг шийдэх, ирээдүйн хамтын ажиллагааны хэлбэрийг боловсруулах гэсэн гурван чухал асуудлыг Их Британи болон ЕХ-ны эрх баригчид 10-р сард багтаан хэлэлцэх ёстой юм. Тус холбооноос гаргах нөхцөлийн талаарх хэлэлцээ өнгөрсөн оны зунаас хойш үргэлжилж байгаа бөгөөд одоогоор тодорхой ахиц дэвшилд хүрээгүй байна.

Япон: Японы компаниудын хувьцааны ханш өсөлттэй хаагдлаа. Иенийн ханш ам.долларын эсрэг бага зэрэг чангарч 112.7 болов.

Японы Ерөнхий сайд ноён Шинзо Абэ Либерал Ардчилсан намын тэргүүнээр ахин сонгогдлоо. Ингэснээр тэрээр ахин 3 жил Японы Ерөнхий сайдын албан тушаалыг хаших юм.

Энэ долоо хоногт Японы төв банкны Ерөнхийлөгч ноён Харухико Курода инфляцийн түвшин 2 хувь хүртэл мөнгөний бодлогондоо өөрчлөлт оруулахгүй тухай мэдээлсэн.

БНХАУ: АНУ Хятадын импортын бараа бүтээгдэхүүнд гаалийн татвар ногдуулж байгаатай холбоотойгоор БНХАУ-ын Засгийн газар дотоодын хэрэглээгээ нэмэгдүүлнэ хэмээн амлалт өглөө. Үүний дараа Хятадын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсч эхэлсэн.

ОХУ: АНУ Ираны эсрэг хориг арга хэмжээ тогтоосноор Иран улсын газрын тосны нийлүүлэлтийг бууруулах магадлалтай гэж хөрөнгө оруулагчид үзжээ. Ингэснээр газрын тосны үнэ нэмэгдэж, түүнийг дагаад ОХУ-ын компаниудын хувьцааны ханш өссөн үзүүлэлттэй байна. ОХУ-ын рублийн ханш ч мөн адил чангарчээ.

Эх сурвалж: Reuters, Troweprice

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	19,942.75	-0.49% ▼
Dow Jones	АНУ	26,743.50	2.25% ▲
S&P 500	АНУ	2,929.67	0.85% ▲
Nasdaq	АНУ	7,986.96	-0.29% ▼
S&P/TSX	Канад	16,224.13	1.32% ▲
FTSE 100	Их Британи	7,490.23	2.55% ▲
S&P/ASX 200	Австрали	6,194.60	0.14% ▲
Nikkei 225	Япон	23,869.93	3.36% ▲
Hang Seng	Хонг Конг	27,953.58	2.45% ▲

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.7%	108.93
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.6%	96.46
Mongol 2022 (Чингис)	USD	5.1%	95.69
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.8%	113.03
DBM' 23 (Самурай)	JPY	1.5%	104.36
TDBM' 2020	USD	9.3%	105.74

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.216	0.05 ▲
Libor 3M	2.373	0.04 ▲
Libor 6M	2.592	0.02 ▲
Libor 1YR	2.908	0.03 ▲
US 6M Bond	2.369	0.04 ▲
US 2YR Bond	2.800	0.02 ▲
US 3YR Bond	2.888	0.03 ▲
US 5YR Bond	2.949	0.05 ▲
US 10YR Bond	3.063	0.07 ▲

Валютын ханш /төг/

Валют	2018.09.21	Өөрчлөлт
USD	2,521.27	0.95% ▲
CNY	368.57	1.05% ▲
EUR	2,968.42	1.41% ▲
RUB	38.05	3.99% ▲
KRW	2.26	0.89% ▲
JPY	22.37	0.13% ▲
CAD	1,953.56	1.61% ▲

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /spot/	USD/t oz.	1,196.50	0.13% ▲
Мөнгө /spot/	USD/t oz.	14.24	1.06% ▲
Зэс	USD/lb.	283.50	8.04% ▲
Нүүрс	USD/MT	111.95	-2.47% ▼
WTI газрын тос	USD/bbl.	71.50	3.70% ▲
Brent газрын тос	USD/bbl.	79.69	2.02% ▲
Байгалийн хий	USD/MMBtu	2.96	6.47% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2018. VIII	6.00%
Бодлогын хүү	2018. VIII	10.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2018. VII	9.80%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2018. VII	12.30%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2018. VII	5.20%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2018. VII	17.60%
Зээлийн дундаж хүү /валют/	2018. VII	10.70%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн бирж дээр 40 компанийн 713.7 сая төгрөгийн 5,807,274 ширхэг хувьцаа арилжигдав.


“Уужим хангай” /SOH/ компанийн хувьцаа 7.57%-аар буюу хамгийн ихээр өсч 270 төгрөгт хүрч хаагдсан бол “Хөвсгөл алтан дуулга” /ADU/ компанийн хувьцаа 25.80%-аар буурч 722 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны зах зээл дээр нийт 141 ширхэг үнэт цаас 15.0 сая төгрөгөөр арилжаалагджээ.


9-р сарын 21-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,322.9 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 19,942.75 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.49%-аар буурсан байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2018 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	728.8
Зах зээлийн үнэлгээ	2,322,859.8

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	19,942.75	-0.49% ▼
MSE I индекс	9,532.70	-0.59% ▼
MSE II индекс	8,962.83	-2.42% ▼

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
Хай Би Ойл	4,174,834	204,603,266
Говь	3,241	103,505,360
Хөвсгөл алтан дуулга	158,425	92,156,296
АПУ	145,841	81,600,068
ЛэндМН ББСБ	916,442	61,207,308

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Уужим хангай	270.00	7.57% ▲
Гутал	21,500.00	7.50% ▲
Усжуулах	700.00	5.26% ▲
АПУ	565.89	4.75% ▲
Улсын их дэлгүүр	485.00	1.04% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Хөвсгөл алтан дуулга	722.00	-25.80% ▼
Хай Би Ойл	49.00	-20.97% ▼
Хөх ган	80.00	-15.16% ▼
Монгол нэхмэл	3,145.00	-15.00% ▼
Эрдэнэт авто зам	695.00	-7.33% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
БиДиСек	18,427,810,270
Голомт Капитал	5,691,801,554
Мирэ Эссет Секьюритис Монгол	4,979,747,108
Бумбат-Алтай	4,856,149,314
Ти Ди Би Капитал	4,755,494,532

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	565.89	602,210
Таван толгой	7,700.00	405,522
Говь	32,020.00	249,792
МИК	10,980.00	227,388
СҮҮ	208.00	71,552

ЗГҮЦ БОЛОН КОМПАНИЙН БОНДЫН АРИЛЖАА

ЗГҮЦ-ны анхдагч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	ZGEB-BD-06/06/19-A0254-15.49	1	103,280	103,280	103,280	104	15.490%
2	ZGEB-BD-20/06/20-A0260-15.14	140	14,894,600	106,390	106,390	156	15.140%

НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Симбол	Компанийн нэр	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Нийт ногдол ашиг /сая төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр	5.00	392.72	2018.08.31	2018.09.10	2018.10.01-2018.11.30
2	ERS	Монгол алт	150.00	39.88	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор
3	TEE	Тээвэр дархан	500.00	81.67	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор
4	TTL	Таван Толгой	2,410.00	126,923.13	2018.04.16	2018.04.03	2018.06.12-нд олгов
5	EER	Ариг гал	21.33	74.21	2018.04.25	2018.04.02	2018.09.01-с
6	BDL	Могойн гол	100.00	82.96	2018.04.26	2018.01.18	2018.06.26-нд олгов
7	DSS	Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ	56.60	7.66	2018.03.07	2018.03.27	2018.07.02-с
8	TAL	Талын гал	50.00	34.71	2018.03.05	2018.04.26	2018.12.31-ний дотор
9	BRC	Барилга корпораци	700.00	28.46	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй
10	AND	Анд-Энерги	1.27	99.15	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй
11	SUL	Жуулчин дютти фрий	10,000.00	653.62	2018.02.23	2018.04.11	2018.05.01-с
12	GTL	Гутал	1,270.00	83.01	2018.02.19	2018.03.18	2018.07.06-с
13	BNG	Баянгол зочид буудал	355.00	150.19	2018.02.19	2018.04.06	2018.09.01-с
14	APU	АПУ	10.00	10,641.82	2018.02.19	2018.03.29	2018.05.17-нд олгов
15	BTG	Баянтээг	100.00	25.26	2018.02.19	2018.03.12	2018.06.01-ний дотор
16	MIE	Материалимпекс	10.00	13.68	2018.02.19	2018.03.26	2018.04.17-нд олгов
17	HRD	Хүрд	497.00	67.23	2018.02.15	2018.02.23	2018.06.30-ны дотор
18	SUU	Сүү	3.00	1,032.00	2018.02.14	2018.04.05	2018.06.04-нд олгов
19	MNP	Монгол шуудан	3.68	366.48	2018.02.13	2018.04.13	2018.06.05-нд олгов
20	MMX	Махимпекс	100.00	380.07	2018.02.13	2018.04.05	2018.10.01-с
21	TCK	Талх чихэр	170.00	174.03	2018.02.12	2018.04.06	2018.07.01-с
22	GHC	Ган Хийц	100.00	24.25	2018.02.09	Тодорхойгүй	Тодорхойгүй
23	ADL	Адуун чулуун	130.00	409.67	2018.02.07	2018.03.01	2018.06.26-нд олгов
24	TAH	Тахь-ко	108.00	128.52	2018.02.05	2018.03.30	2018.05.01-ний дотор
25	UBH	Улаанбаатар хивс	100.00	40.48	2018.02.05	2018.02.26	2018.05.01-с
26	GOV	Говь	220.00	1,716.25	2018.02.02	2018.03.27	2018.04.24-с олгов
27	HRM	Гермес центр	5.00	392.72	2018.01.24	2018.02.15	2018.04.12-нд олгов

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Мандал даатгал” ХК-ийн үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа 2018.09.24-нд эхэлнэ

Санхүүгийн зохицуулах хорооноос “Мандал даатгал” ХК-ийн анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсонд тооцож, тус компанийн үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг 2018 оны 9-р сарын 24-ний өдрөөс эхлүүлэх зөвшөөрлийг 2018 оны 9-р сарын 21-ний өдрийн 1/3778 тоот албан бичгээр олгосон байна.

Тус компани нь нийт хувьцааныхаа 25 хувийг олон нийтэд санал болгож 7.4 тэрбум төгрөгийг олон нийтээс татан төвлөрүүлсэн. “Мандал Даатгал” ХК-ийн олон нийтэд санал болгосон хувьцааны анхдагч зах зээлийн арилжаанд 863 хувь хүн, аж ахуйн нэгж оролцож, нийтдээ 1,916,207 ширхэг хувьцаа худалдан авах захиалга ирүүлсэн нь олон нийтэд санал болгосон дүнгээс 23 хувиар давсан үзүүлэлт болсон.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж



“Ард даатгал” ХК-ийн үнэт цаасны анхдагч зах зээлийн захиалга авах мэдээлэл

Монголын хөрөнгийн биржийн 2018 оны 6 дахь шинэ үнэт цаас, даатгалын салбараас үнэт цаасаа олон нийтэд санал болгон гаргаж буй анхны компани болох “Ард даатгал” ХК нь нийт хувьцааныхаа 30 хувь буюу 7.5 сая ширхэг хувьцааг нэг бүрийг нь 700 төгрөгөөр олон нийтэд санал болгон худалдаалж, нийт 5.4 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэхээр анхдагч зах зээлийн сурталчилгааг эхлүүлээд байгаа билээ.

Тус компани нь олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгөөр хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж, эрсдэл даах чадварыг сайжруулах, түүнчлэн, СЗХ-ноос батлагдсан “Ердийн даатгалын компанийн даатгалын нөөц сангаас хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлага”-ын дагуу зарцуулахаар төлөвлөсөн байна.

Нийт захиалгын тоо хэмжээ санал болгож буй хэмжээнээс давсан тохиолдолд “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн “Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам”-ын дагуу хувь тэнцүүлэх зарчмаар нийт хөрөнгө оруулагчдад хуваарилна.

Үнэт цаасны худалдан авах захиалгыг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн гишүүн бүх үнэт цаасны компаниудаар дамжуулан 2018 оны 9-р сарын 17-ны өдрөөс 9-р сарын 26-ны өдрийн 14:00 цаг хүртэл хүлээн авна.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж



МХБ: “Хөсөг трейд” ХК энэ онд 2 дахь удаагаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаа зарлав

Ирэх нэг сарын хугацаанд Монголын Хөрөнгийн биржид бүртгэлтэй таван компани хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаа хийхээр зарлаад байна.

Тухайлбал, энэ сарын 29-нд “Монгол шевро” компани хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаа хийхээр товлоод байгаа аж. Хурлаар зарим их хэмжээний хэлцлийг батална гэж тусгасан байна. Харин аравдугаар сарын 3, 4, 5-нд “Говь”, “Хөсөг трейд”, “Монинжбар” компаниуд ээлжит бус хурлаа хийхээр төлөвлөжээ.

“Говь” компани хувьцаагаа 100 дахин хуваах асуудлыг хэлэлцэхээр байна. Одоогоор тус компанийн 84.2 хувийг гурван хувьцаа эзэмшигч, үлдсэн 15.8 хувийг 16.2 мянган жижиг хувьцаа эзэмшигчид эзэмшиж байгаа юм.

Харин “Хөсөг трейд” компани энэ онд хоёр дахь удаагаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаа хийх гэж байна. Өмнөх хурлаар ТУЗ-ийн гишүүдийн бүтцэд өөрчлөлт оруулах байсан ч хойшлуулах шийдвэр гаргажээ. Энэ удаагийн хурлаар хувьцааны өмчлөлийн бүртгэлд өөрчлөлт оруулахаар тусгасан байна.

Үүнээс гадна “Монинжбар” компани компанийнхаа нэрийг өөрчилнэ гэж мэдээлжээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

“Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн”-ээс ирүүлсэн мэдэгдэл

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци Баянхонгор аймагт байрлах өөрийн 100% эзэмшлийн Хөндий алтны төслийн нөөцийг Канад улсын нөөц тайлагнах NI 43-101 тайлагналын стандартын дагуу олон нийтэд танилцуулсан байна.

Хөндий алтны төсөл нь хоорондоо 16 км зайд орших Баян Хөндий алтны орд болон Алтан Нар алтны ордуудыг хамардаг. Энэхүү хэвлэлийн мэдээгээр 2018 оны 5-р сард танилцуулсан Алтан Нар ордын нөөцийн хэмжээг үнэмлэхүй хэмжээгээр нэмж шинэчилсэн нөөцийн тайланг Баян Хөндий ордын нөөцийн тайлантай нэгтгэн танилцуулж байна. Дээрх хоёр орд нь шинээр илрүүлсэн Хөндий алтны дүүрэгт оршдог бөгөөд эрдэсжилт нь газрын гадаргаас ойр, өндөр агуулгатайгаараа онцлог юм.

Нөөцийн тайлангийн онцлох мэдээ:

- Хөндий алтны төслийн нийт нөөц: - 2.3 г/т алтны дундаж агуулга бүхий 751,000 унц алтны бодит нөөц, - 1.8 г/т алтны дундаж агуулга бүхий 291,000 унц алтны боломжит нөөц.
- 1.4 г/т алтны захын агуулгаар тооцвол Хөндий алтны төсөл нь: - 3.7 г/т алтны дундаж агуулга бүхий 642,000 унц алтны бодит нөөц, үүнд Баян Хөндий ордын 5.2 г/т алтны дундаж агуулга бүхий 357,000 унц бодит нөөц багтаж байна.
- Хөндий алтны төслийн полиметалл болон үнэт металлыг агуулснаар: - 2.7 г/т AuEq (алтны дүйцэх нэгж буюу “алтны эквивалент”) агуулгатай 886,000 унц бодит нөөц, - 2.3 г/т AuEq агуулгатай 382,000 унц боломжит нөөц агуулагдаж байгааг танилцуулаа.
- Эрдэнэ Ресурс нь Хөндий алтны төслийн анхан шатны эдийн засгийн тооцооллыг хийж эхлүүлсэн бөгөөд 2018 оны 4-р улиралд эцэслэхээр төлөвлөж байна.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ХААБ: 4-8 сард 4,200 гаруй тонн ямааны ноолуур арилжсан

Түүхий эдийн арилжаа идэвхждэг 4-8 дугаар сард Хөдөө аж ахуйн биржид нийт 4,200 гаруй тонн ямааны ноолуур арилжсан байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 21.1 хувиар буурсан үзүүлэлт болжээ.

Хэдийгээр арилжсан хэмжээ нь буурсан ч энэ онд ноолуурын үнэ өссөнтэй холбоотойгоор арилжааны үнийн дүн 2.7 хувиар өссөн байна. Тухайлбал, энэ оны 4-8 дугаар сард боловсруулаагүй цайвар ноолуурын ханш 99-107 мянган төгрөгийн хооронд хэлбэлзэж байсан юм. Харин өмнөх оны мөн үед 63-96 мянган төгрөгөөр арилжиж байсан аж. Мөн боловсруулаагүй бараан ноолуурын ханш энэ онд 50 орчим хувиар өсөж, 105 мянган төгрөгт хүрчээ.

Оны эхний найман сарын байдлаар нийт 2,64.1 сая ам.долларын самнасан болон бохир ноолуур экспортолсон нь өмнөх оны мөн үеэс 24.5 хувиар өссөн үзүүлэлт болсон байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

BI: Алтны ханш 1,400 ам.доллар хүртэл өсч магадгүй

Алтны ханш сүүлийн нэг жилийн хугацаанд 8.15 хувиар суларч 1200 ам.доллараас доош бугаад байна. Гэхдээ "Bloomberg Intelligence"-ийн таваарын зах зээлийн шинжээчдийн тооцоолсноор ханш 1400 ам.доллар хүртэл өсөх магадлалтай байгаа юм байна.

Буурах эрсдэлийг тооцвол ирэх нэг жилийн хугацаанд ам.доллар тогтвортой чангарахтай зэрэгцээд хөрөнгийн биржийн индексүүд тасралтгүй өссөн нөхцөлд л шар металлын ханш 1120 ам.доллараас доош буух боломжтой юм байна. Гэхдээ түүхэн индикаторуудыг харахад ингэх магадлал маш бага гэж шинжээчид үзэж байгаа. Харин 2017 онд ам.долларт ажиглагдсан өмнөх дундаж ханшдаа эргэж очих хөдөлгөөн давтагдвал унци алтны үнэлгээ 1400 ам.долларт ойртох боломжтой юм байна.

Холбооны нөөцийн банк мөнгөний бодлогоо чангатгах үед биржид бүртгэлтэй хөрөнгө оруулалтын сангууд эзэмшил дэх алтны хэмжээгээ өсгөж байсныг түүхэн үзүүлэлтээс харж болохоор байна. Тухайлбал, АНУ-ын Төв банк бодлогын хүүгээ анх удаа нэмсний дараа эдгээр сангуудын эзэмшил дэх алт 47 хувиар өсжээ. 2013 оноос хойш алтны ханш 52 хоногийн дундажаас наймаас илүү хувиар доогуур түвшинд тогтож байгаагүй. Цаашдаа ханш унах нөхцөл байхгүй гэж "Bloomberg"-ийн шинжээчид дүгнэсэн.

Энэ оны IV сард "Bloomberg"-ийн долларын спот индекс болон S&P 500 индексийн аль аль нь унаснаар алтны ханш 1400 ам.доллар хүртэл өсөж байсан. Үүнээс хойш хөрөнгийн зах зээл сэргэж, ам.долларын ханш чангарахад эргээд буурч 1200 доллар орчимд тогтсон. Гэхдээ зах зээлийн тоглогчид хөрөнгийн бүтцээ хэт богино хугацаанд өөрчилсөн нь алтны үнэлгээг зохих түвшнээсээ доор тогтоход хүргэсэн гэж шинжээчид дүгнэж байгаа юм.

Алтны өнөөгийн ханшийн хөдөлгөөн 1999 онд 3 долоо хоногт 34 хувиар өссөн үеийг санагдуулахаар байгаа юм байна. Хэрэв төстэй үйл явдал болбол ирэх сард 1600 ам.доллар ч хүрч мэднэ гэж "Bloomberg"-ийн шинжээчид үзэж байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

АМГТГ: 2018 онд 21 ААН нүүрс экспортолж байна

2018 онд компаниуд нийт 77 уулын ажлын төлөвлөгөө боловсруулж, батлуулснаас 32 нь нүүрсээ экспортолж талаар тусгасан байна. Үүнээс 21 аж ахуйн нэгж нүүрс экспортолж байгаа талаар Ашигт малтмал, Газрын тосны газар мэдээллээ. Өнгөрсөн онд экспортын төлөвлөгөөгөө уулын ажлын төлөвлөгөөнд тусгасан 20 компани байсан бөгөөд үүнээс 18 нь экспорт хийсэн байна. Энэ оны төлөвлөгөөнөөс харахад компаниуд Өмнөговь аймагт хамгийн олон буюу 17 нүүрсний талбайд үйл ажилладагаага явуулж байгаа бол Дорноговь аймагт 13, Сүхбаатар аймагт 11 талбайгаас нүүрс экспортолж байна. Гол экспортлогчдоос дурдвал Хонгконгийн Хөрөнгийн биржид бүртгэлтэй "Mongolia Energy Corporation" Хөшөөтийн ордоос нүүрс гаргаж байгаа аж. Тус компани энэ онд нэг сая тонн баяжуулсан нүүрс гаргахаар төлөвлөж байгаагаа мэдэгджээ.

Харин "Эрдэнэс Тавантолгой" ХК энэ оны эцэст 13 сая тонн нүүрс борлуулахаар зорьж байна. Орон нутгийн өмчит "Тавантолгой" ХК 2018 онд дөрвөн сая тонн нүүрс олборлон борлуулахаар төлөвлөсөн талаараа үйл ажиллагааны тайландаа дурджээ.

Эх сурвалж: BloombergTv.mn



"Эрдэнэс таван толгой" ХК-ийн нөөцийг 7.6-8 тэрбум тонноор тогтоогоод байна

Төрийн өмчит "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн нүүрсний ордын нөөцийг 6 тэрбум 48 сая тонн гэж Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс тогтоосон байдаг.

Тус ордын нүүрсний нөөцийг анх 1981 онд хийж, 5.1 тэрбум тонн гэж дүгнэж байжээ. Түүнээс хойш 40-өөд жилийн дараа дахин тогтооход нөөцийн хэмжээ өмнөхөөсөө нэмэгдсэн байна. Энэ талаар "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Ганхуягаас тодруулахад, "Анх 5.1 тэрбум тонн нүүрсний нөөцтэй гарсан нь хэсэгчилсэн тайлангаар тийм байсан юм. 1981 оноос хойш хэсэг хэсэг газар хайгуул хийгээд хайгуулын тайлангаар тийм гарч байсан юм.

Түүнээс хойш Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр ороод бид анх удаа буюу 40 жилийн дараа компанийн ордын нэгдсэн тайлан батлуулж авснаар нөөц нь 6 тэрбум тонн болсон. Үүний дараа бид 2014 оноос хойш тасалдаад байсан хайгуулын ажлыг 2017-2018 онд 130 орчим мянган тууш метр талбайд хийж, үүний хүрээнд 340 сая тонн нүүрсийг нэмж баталгаажуулж авсан. Ингээд блокын аргачлалаар 6.3 тэрбум тонн нөөцтэй болсон юм. Өмнө манай компани 5.1 тэрбум тонны нөөцөө дэлхийд жорк стандартаар 7.3 тэрбум тонн гэж олон улсад танилцуулсан юм. Энэ нь жорк буюу өөр ангилалтай байдаг. Тиймээс өнөөдрийн байдлаар 6.3 тэрбум тонн байгаа нөөцөө олон улсын жорк стандартад шилжүүлснээр танилцуулахад "ЭТТ" ХК-ийн нүүрсний нөөц 7.6-аас 8 тэрбум тонн буюу, түүнээс дээш үнэлгээгээр тогтоогдож байна. Энэ хэмжээгээр компанийн үнэлгээ, нөөцийн үнэлгээ, үнэ цэнэ нэмэгдэх юм" гэв.

Эх сурвалж: Montsame.mn

БУСАД МЭДЭЭ

World Economics: Монголын ажил эрхлэлтийн түвшин сүүлийн 5 жилийн дээд түвшинд хүрлээ

9-р сард Монгол Улсын борлуулалтын менежерүүдийн индекс 58.3 нэгж байгаа нь өмнөх сараас өөрчлөгдөөгүй ч өсөлтийн бүсэд хэвээр байгааг “World Economics” байгууллага мэдээллээ. Хэдий тийм боловч энэхүү индекс сүүлийн дөрвөн сар орчмын доод түвшинд хадгалагдаж байгаа юм.

“World Economics” байгууллага Монголын борлуулалтын менежерүүдийн индексийг тооцохдоо үндсэн таван төрлийн үзүүлэлтийг тооцдог. Эдгээрт бизнесийн итгэлийн индекс, зах зээлийн өсөлт, борлуулалт, үнийн өөрчлөлт, ажил эрхлэлтийн түвшин зэрэг багтдаг.

Ажил эрхлэлтийн түвшин 61.7 нэгжид хүрч өссөн нь сүүлийн таван жилийн дээд түвшинд хүрсэн үзүүлэлт болж байна.

Мөн энэ оны дөрөвдүгээр сараас хойш үнийн өөрчлөлт 50-иас дээш нэгжид хэлбэлзэж байгааг онцоллоо. Өөрөөр хэлбэл инфляци эрчимжиж байгааг “World Economics” байгууллагын судалгаанаас харах боломжтой байна. Үндэсний статистикийн хорооны мэдээлснээр инфляци 8-р сарын байдлаар 6 хувь буюу Төв банкны зорилтот түвшинтэй ойролцоо байгаа ажээ.

Үүнээс гадна он гарснаас хойш бизнесийн итгэлийн индекс өсөлтийн бүсэд хадгалагдаж байгааг тус судалгааны байгууллага онцолж байна. Өөрөөр хэлбэл цаашид бизнесийн орчин сайжирна гэсэн хүлээлт зах зээлд өндөр байгаа юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

Монголбанк: Мөнгөний бодлогын талаар баримтлах чиглэлд финтекийн асуудлыг тусгана

2019 онд Төрөөс Мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлд финтекийн асуудлыг тусгана гэж Төв банк мэдээллээ. Энэ онд батлагдсан Үндэсний төлбөрийн системийн тухай хуулиар финтек ашиглан төлбөр тооцооны үйл ажиллагаа явуулах компаниудын асуудлыг Төв банк хариуцахаар болсон юм. Финтек нь санхүүгийн салбарт шинээр нэвтэрч байгаа учраас нууцлал, аюулгүй байдал, хуучин эрх зүйн зохицуулалт зэрэг хүндрэлүүд тулгарч байгааг Төв банкны төлбөр тооцооны газар мэдээллээ.

Дэлхий дахинд хиймэл оюун ухааны “бот”-ууд, “Peer to peer” зээл, биометрик, блокчэйн технологи, бизнес хоорондын төлбөр тооцоо зэрэг олон хэлбэрээр финтек хөгжиж байна. Үүнээс Монголд “цахим мөнгө”, “Q Pay”, бичил зээл шуурхай олгох үйлчилгээ өргөн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгааг Төв банк онцолж байгаа юм.

Эх сурвалж: BloombergTv.mn



Монголбанк: Мөнгөний бодлогын шийдвэр бизнесийн идэвхжлийг дэмжинэ

Бодлогын хүүг 10 хувьд хэвээр хадгалах шийдвэр нь эдийн засаг бизнесийн идэвхжлийг дэмжинэ гэж Төв банк мэдээллээ. Мөн макро зохистой бодлогын хүрээнд ипотекийн бус иргэдийн хэрэглээний зээлийн хугацааг 30 сараас хэтрүүлэхгүй байх, валютын зээлийн эрсдэлийн жинг 120 хувиас нэмэгдүүлж 150 хувьд хүргэх шийдвэр гарган билээ.

Макро зохистой бодлогын шийдвэрүүд 2019 оны нэгдүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлнэ. Зээлийн өсөлт нь өрхийн өр, импортын хэмжээг нэмэгдүүлж санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй. Тиймээс хэрэглээний зээлийг хязгаарлах бодлого барьж байгаагаа Төв банк тайлбарлалаа.

6-р сард болсон хуралдаанаар хэрэглээний зээлийн өр, орлогын харьцааны дээд хязгаарыг 70 хувиар тогтоох шийдвэр гаргасан. Энэ удаад хугацааг 30 сараар хязгаарласан нь онцлог болж байна. Мөн гадаад валютын зээлийн эрсдэлийг бууруулах, хязгаарлах үүднээс эрсдэлийн жинг нэмэгдүүлсэн байна.

Харин гадаад секторын нөлөөгөөр эдийн засагт үүсч болзошгүй эрсдэл зэргийг харгалзан үзэж бодлогын хүүг өөрчлөх эсэх, макро зохистой бодлогын хязгаарлалтыг зөрчсөн бол авах арга хэмжээний тухай асуудлыг дараагийн хуралдаанаар хэлэлцэх аж.

Эх сурвалж: BloombergTv.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.